

ДУУЛГАХ СӨНИН Монголыг хөдөө аж ахуйн орон болох тухай уншиж байлаа.

Би профессор болно

ХБНГУ-ын Холбооны Ерөнхийлөгч Р.Херцогийг дагалдан ирсэн Х.Айслерийн нэрэмжит Хөгжмийн дээд сургуулийн оюутан, төгөлдөр хуурч Каролине Фишер 14 настай. Тэр Германд жил бүр зохиогддог «Залуус хөгжимдөж байна» уралдааны зургаан удаагийн тэргүүн байрын шагналт, Берлиний Штайнвейны нэрэмжит уралдааны (1993, 1996) хоёрдугаар байрын шагналт, 1994 онд Чех улсад болсон өсвөрийн төгөлдөр хуурчдын олон улсын уралдааны тэргүүн байрын шагналтай, Гоц авьяастан.



-Таны тоглолтыг үзээд өндөр сэтгэгдэл төрлөө. Миний анзаарснаар та их тайван хүн шиг байна?

-Тийм ээ.

-Тайзан дээр гарахдаа ч сандардаггүй юу?

-Үгүй.

-Тэгвэл энэ чанар сонгодог хөгжмөөр хичээллэдгийн үр дүн мөн үү?

-Тийм ч байж болно.

-Сая та Шопен, Лист, Менделсоны зохиолуудыг тоглолоо. Энэ таны сонголт уу?

-Тийм ээ. Тэгэхдээ багштайгаа зөвлөж гүйх явахав. Ер нь би романтик чиглэлийн хөнгөн уриан, уянгын хөгжимд дуртай.

-Хамгийн дуртай хөгжмийн зохиолч тань?

-Шопен

-Орчин үеийн төгөлдөр хуурт зориулсан зохиолд хэрхэн ханддаг вэ. Тогло-

дог уу?

-Би дургүй.

-Одоо өөр зүйлийн тухай ярь. Есөн настайдаа оюутан болсон гэсэн. Танай сургуульд үеийн тань хүүхдүүд олон уу?

-Өөр ангиудад ганц, хоёр бий.

-Ачаалал их үү. Өдөрт олон цаг давтдаг уу?

-2-3 цаг.

-Шинэ зохиолд, жишээ нь нэг концерт гартаа оруулахын тулд ямар хугацаа зарцуулдаг вэ?

-Дөрвөн долоо хоног.

-Чөлөөт цагийн тухайд?

-Агаарын теннис тоглож, усанд сэлдэг. Зав гарвал ном уншина.

-Ямар номд илүү дуртай вэ?

-Детектив зохиолд. Нэмж хэлэхэд зав тун бага.

-Ерөнхийлөгчтэй хамт ирэх болсон түүхээсээ

сонирхуулаач?

-Өнгөрсөн тавдугаар сард түүний гэргийд зориулсан үдэшлэгт би тоглосон юм. Тэгэхэд намайг авч, явахаар шийдсэн гэсэн.

-Монгол орны тухай ямар мэдлэг, мэдээлэлтэй байв даа?

-Хөдөө аж ахуйн орон болох тухай номноос уншиж байлаа. Үнэхээр ч тийм юм.

-Өөр олон орноор явсан уу?

-Чех, Өмнөд Солонгост байсан.

-Уучлаарай. Та ази гаралтай хүн юм. Аав, ээжийгээ танилцуулахгүй юу?

-Миний аав герман, ээж солонгос үндэстэн.

-Тэдний мэргэжил?

-Аав фото зурагчин, ээж минь анагаах ухааны чиглэлийн хүн л дээ.

-Өөрийнхөө ирээдүйг яаж төсөөлж байна вэ?

-Илүү ихийг тоглохыг хүсэж байна. Тоглогч байхаас гадна дээд сургуулийн багш болж, профессор болно гэлээ.

«Сургуулиа хэзээ төгсөх вэ» гэж асуухад хариу хэлэлгүй, нүдээ эргэлдүүлэн, толгойгоо үл ялиг гийлж илгэсэнээ босоод явчихлаа. Газар шүргэм урт хар даашинзаа өргөж гүйх шахам очиж ээжээсээ асуучихаад эргээд хурдаллаа. Тэр гурван жилийн дараа сургуулиа төгсөнө. Аливаа юманд нягт, нямбай, яв цав ханддаг германчуудын зан чанарын илрэл энэ өчүүхэн асуултын тодорхой хариулт биз ээ.

Р.ОЮУНЖАРГАЛ